



МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

20 18 оны 08 дугаар
сарын 30 -ны өдөр

Дугаар 98

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1.5-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын хяналтын байцаагчид эрх олгох, сунгах, цуцлах журам”-ыг нэгдүгээр, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн хувийн дугаар бүхий шалгах эрхийн үнэмлэх, энгэрийн тэмдэг, баталгааны тэмдэг, эрх зүйн баримт бичгийн хэвлэмэл хуудасны загварыг хоёрдугаар, Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн хувийн дугаар бүхий шалгах эрхийн үнэмлэх, энгэрийн тэмдэг, баталгааны тэмдэг, эрх зүйн баримт бичгийн хэвлэмэл хуудасны загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газар (хошууч генерал Т.Бадрал)-т үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монгол Улсын сайдын 2006 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 52 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Шадар сайд



Ө.ЭНХТҮВШИН

Монгол Улсын Шадар сайдын
2018 оны 9 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ БОЛОН ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН
ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН ЭРХ ОЛГОХ, СУНГАХ,
ЦУЦЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, гал түймрийн улсын хяналтын байцаагч /цаашид “улсын хяналтын байцаагч” гэх/-ийн эрх олгох, сунгах, цуцлах харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Улсын хяналтын байцаагчийн эрхийг гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын чиглэлээр олгоно.

Хоёр. Улсын хяналтын байцаагчид эрх олгоход
тавигдах шаардлага

2.1. Улсын хяналтын байцаагчид тавигдах шаардлага:

2.1.1. “Төрийн албаны тухай” хуулийн 22 дугаар зүйлд заасан төрийн албан тушаалд тавигдах нийтлэг шаардлагыг хангасан байх,

2.1.2. гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын чиглэлээр мэргэжил эзэмшсэн дээд боловсролтой байх,

2.1.3. улсын хяналтын байцаагч нь онцгой байдлын байгууллагад офицерын албан тушаалд 3-аас доошгүй жил, ахлах байцаагч нь улсын хяналтын байцаагчаар 2-оос доошгүй жил ажилласан байх,

2.1.4. ашиг сонирхлын зөрчилгүй байх,

Гурав. Улсын хяналтын байцаагчийн
эрх олгох, сунгах, цуцлах

3.1. Энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан алба хаагч улсын хяналтыг хэрэгжүүлэх эрх олгох шалгалтад тэнцсэн тохиолдолд улсын хяналтын байцаагчийн эрх олгоно.

3.2. Улсын хяналтын байцаагчийн эрх олгох:

3.2.1. гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчийн эрх олгох саналыг гамшгийн шуурхай удирдлагын бүтцийн нэгж, гал түймэртэй тэмцэх бүтцийн нэгжээс улсын хяналтын ерөнхий байцаагчид гаргана.

3.2.2. улсын хяналтын байцаагчийн эрх олгох шалгалтыг ерөнхий байцаагчийн томилсон ажлын хэсэг зохион байгуулна.

3.2.3. эрх олгох, шалгалттай холбоотой маргааныг ажлын хэсгийн ахлагч улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулж шийдвэрлэнэ.

3.2.4. улсын хяналтын байцаагчийн эрх олгох шалгалтыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах бөгөөд хугацааг ерөнхий байцаагч тогтооно.

3.2.5. улсын хяналтын байцаагчийн эрхийг 3 жилийн хугацаатай олгоно.

3.2.6. шалгалтад тэнцэж улсын хяналтын байцаагчийн эрх авсан алба хаагчид хувийн дугаар бүхий шалгах эрхийн үнэмлэх, энгэрийн тэмдэг, баталгааны тэмдэг олгоно.

3.3. Улсын хяналтын байцаагчийн эрхийг сунгах:

3.3.1. улсын хяналтын байцаагчийн эрхийн хугацаа дууссан тохиолдолд эрх олгох шалгалтад хамрагдана.

3.3.2. улсын хяналтын байцаагчийн эрх олгох шалгалтад тэнцсэн бол 2 жилийн хугацаагаар сунгана.

3.4. Улсын хяналтын байцаагчийн эрхийг дараах тохиолдолд цуцлана:

3.4.1. улсын хяналтын байцаагч нь өөр албан тушаалд томилогдсон, ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан, цэргийн алба хаасны тэтгэвэрт гарсан,

3.4.2. улсын хяналтын байцаагч нь улсын хяналт, шалгалтын чиглэлээр хууль тогтоомж зөрчсөн, ашиг сонирхлын зөрчил үүссэн, гэмт хэрэгт холбогдон хууль хяналтын байгууллагад сэжигтэн, яллагдагчаар татагдсан,

3.4.3. улсын хяналтын байцаагч нь 6 сараас дээш хугацаагаар эмчлүүлэх, сувилуулах, сургалт, дадлагад хамрагдах болсон,

3.4.4. улсын хяналтын байцаагч нь албан тушаал /ажлын байр/-ны тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хангалтгүй биелүүлж, байцаагчийн ажлын үзүүлэлтийг удаа дараа хангаагүй,

3.4.5. өөрийн санаачлагаар чөлөөлөгдөх хүсэлт гаргасан,

3.5. эрхийг нь цуцалсан улсын хяналтын байцаагчийн хувийн дугаар бүхий шалгах эрхийн үнэмлэх, энгэрийн тэмдэг, баталгааны тэмдгийг Захиргааны удирдлагын бүтцийн нэгж, аймаг, орон нутагт хүний нөөц, дотоод ажил, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн хураан авна.

Дөрөв. Бусад

4.1. Улсын хяналтын байцаагчийн албан тушаалыг өөрчлөх, сэлгэн томилох, сургах болон бусад холбогдолтой шийдвэрийг гаргахдаа Онцгой байдлын ерөнхий

газрын гамшгийн шуурхай удирдлагын бүтцийн нэгж, гал түймэртэй тэмцэх бүтцийн нэгжтэй зөвшилцөнө.


4.2. Улсын хяналтын байцаагч нь заавал биелүүлэх албан шаардлага, дүгнэлт, мэдэгдэл, танилцуулга, акт, хяналт шалгалт хийсэн тухай тэмдэглэл, тогтоол зэрэг эрх зүйн баримт бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Тав. Хариуцлага

5.1. Улсын хяналтын байцаагчийн хувийн дугаар бүхий эрхийн үнэмлэх, энгэрийн тэмдэг, баталгааны тэмдгийг бусдад шилжүүлэх, ашиглуулах, барьцаалах, хадгалуулах, үрэгдүүлэх, гэмтээх, хууль бусаар хийлгэх, хэлбэр загварыг өөрчлөх, хувилах, албан үүргээ гүйцэтгэхээс бусад тохиолдолд ашиглахыг хориглоно,

5.2. Улсын хяналтын байцаагчийн гаргасан зөрчил нь эрүүгийн болон зөрчлийн хариуцлага хүлээлгэхээргүй бол сахилгын шийтгэл ноогдуулна.

--- оОо ---



Нүүр тал

МОНГОЛ УЛСЫН ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
THE NATIONAL EMERGENCY MANAGEMENT AGENCY OF MONGOLIA
ГОСУДАРСТВЕННОЙ АГЕНТСТВО ПО ЧРЕЗВЫЧАЙНЫМ СИТУАЦИЯМ МОНГОЛИИ

Зураг 2/3

Дугаар

Овог:
Нэр: нь

“Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч”
тул үнэмлэх олгов.

Гамшгаас хамгаалах улсын хяналтын ерөнхий байцаагч,
хошууч генерал Т.Бадрал

Олгосон: 20 ... он ... сар ... өдөр
Хүчинтэй хугацаа: 20 ... он ... сар ... өдөр

88 мм

55 мм

Ар Тал

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН ЭРХ

- Хууль тогтоомжоор болон түүнийг үндэслэн төрийн эрх бүхий байгууллагаас удирдлагын тодорхой салбарт нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон тусгай журмын биелэлтэд хяналт тавих;
- Хяналт шалгалт хийх объектод саадгүй нэвтрэн орох;
- Хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;
- Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, шууд буюу шууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох үзэх зохих ёсоор нотлогдсон, түүнчлэн осол аюул гарч болох тохиолдолд холбогдох ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн зөрчлийг арилгах хүртэл түр зогсоох, шаардлагатай зүйлийг ариутгах, хоргуйжүүлж цэвэршүүлэх, тухайн барилга байгууламж, машин, тонно төхөөрөмжийн ашиглалтыг зогсоох, холбогдох бүтээгдэхүүнийг худалдаа, борлуулахыг хориглох, устгах буюу зохих шаардлагад харшлахгүй бол өөр ариулалтаар ашиглах шийдвэр гаргах, энэ тухай олон нийтэд зарлан мэдээлэх;
- Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөл, шалтгааныг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах;

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хоёрдугаар бүлгийн 10.9 дүгээр

88 мм

55 мм

--- оОо ---

Хоёр: Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн
энгэрийн тэмдгийн загвар



- Ерөнхий өнгө алтлаг шар өнгийн товгор
- Үсэг, дугаарын суурь мөнгөлөг өнгөтэй
- Эмблем товгор, шиллэг лакан өнгөлгөөтэй
- Байцаагчийн энгэрийн тэмдэг нь 50 мм x 50 мм байна

Гурав: Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн хувийн
дугаар бүхий баталгааны тэмдгийн загвар



- Байцаагчийн баталгааны тэмдэг нь улаан өнгөтэй
- Тэмдгийн гол хэсэгт Онцгой байдлын албаны лого
логоны доод хэсэгт ерөнхий, ахлах, байцаагчийн
хувийн дугаар байна.
- Ерөнхий болон ахлах байцаагчийн тэмдэг 45 мм
Байцаагчийн тэмдэг 40 мм-ийн диаметртэй байна.



**АРХАНГАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН
ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН**

АЖИЛЛАГАА ЗОГСООХ ТОГТООЛ

_____ оны ____ сарын _____ дугаар _____ хот

Гамшгаас хамгаалах улсын хяналтын (ахлах) байцаагч албан тушаалтайцолтой
.....би.....
..... - ны гамшиг, аюулт үзэгдэл,
ослоос хамгаалагдсан байдлыг шалгаад:

ОЛСОН НЬ:

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

.....байгаа зэрэг
нь гамшиг, аюулт үзэгдэл, осол гарах бодит аюул бүрдсэн, гамшгийн улмаас хүний амь нас, эрүүл
мэнд, эд хөрөнгийг авран хамгаалах боломжгүй, хүрээлэн байгаа орчинд ихээхэн хэмжээний
хохирол учруулж болох тул Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9.7-д заасныг үндэслэн

ТОГТООХ НЬ:

1. – ны
үйл ажиллагааг 20 ... оны ... дугаар сарын ... - ны өдрийн цагаас эхлэн түр зогсоосугай.
2. – ны
ажиллагааг зогсоосон тухай нд албан
ёсоор мэдэгдсүгэй.
3. Энэхүү тогтоол нь заагдсан зөрчлийг бүрэн арилгасны дараа гамшгаас хамгаалах улсын
хяналтын (ахлах) байцаагчаас ажиллагааг явуулах дүгнэлт гаргах хүртэл хүчин төгөлдөр байна.
4. Тогтоолыг эс зөвшөөрвөл 10 хоногийн дотор шүүх болон дээд шатны байгууллагад
гомдлоо гаргах эрхтэй.

.....аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн гамшгаас
хамгаалах улсын хяналтын (ахлах) байцаагч албан тушаалтай, цолтой
..... -ын /

Тогтоолыг хүлээн авсан: / Гарын үсэг /



**АРХАНГАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН
ЗААВАЛ БИЕЛҮҮЛЭХ АЛБАН ШААРДЛАГА**


_____ оны ____ сарын _____

дугаар _____

_____ хот

Г

Г





АРХАНГАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН
ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН МЭДЭГДЭЛ


_____ оны _____ сарын _____

дугаар _____

_____ хот

Г

Г



Долоо



**АРХАНГАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН
БАЙЦААГЧИЙН АКТ**


_____ оны ____ сарын _____

дугаар _____

_____ хот

Г

Т





АРХАНГАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН
ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ


_____оны _____сарын _____

дугаар _____

_____хот

Г

Г





**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН
ТАНИЛЦУУЛГА**


_____ оны ____ сарын _____



дугаар _____

_____ хот

Г

Т





Хоёр. Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн хувийн дугаар бүхий энгэрийн тэмдгийн загвар



- Ерөнхий өнгө алтлаг шар өнгийн товгор
- Үсэг, дугаарын суурь мөнгөлөг өнгөтэй
- Эмблем товгор, шиллэг лакан өнгөлгөөтэй
- Байцаагчийн энгэрийн тэмдэг нь 50 мм х 50 мм байна

Гурав. Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн хувийн дугаар бүхий баталгааны тэмдгийн загвар



- Байцаагчийн баталгааны тэмдэг нь улаан өнгөтэй
- Тэмдгийн гол хэсэгт Онцгой байдлын албаны лого
- логоны доод хэсэгт ерөнхий, ахлах, байцаагчийн хувийн дугаар байна.
- Ерөнхий болон ахлах байцаагчийн тэмдэг 45 мм
- Байцаагчийн тэмдэг 40 мм-ийн диаметртэй байна.



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ
БАЙДЛЫН ГАЗАР
ХЯНАСАН

20 . . ОНЫ . . . -Р САРЫН . . . -НИЙ ӨДӨР
ГАРЫН ҮСЭГ:

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



МОНГОЛ УЛС
АРХАНГАЙ АЙМГИЙН
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
ХЯНАСАН

20 . . ОНЫ . . . -Р САРЫН . . . -НИЙ ӨДӨР
ГАРЫН ҮСЭГ:

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



АРХАНГАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН
ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН

АЖИЛЛАГАА ЗОГСООХ ТОГТООЛ

_____ оны _____ сарын _____ дугаар _____ хот

Г _____ Т _____

Гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагч албан тушаалтайцолтой
.....би.....
..... - ны галын аюулаас хамгаалагдсан
байдлыг шалгаад:

ОЛСОН НЬ:

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

.....байгаа зэрэг
нь гал түймэр гарах бодит аюул бүрдсэн, гал түймрийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд
хөрөнгийг авран хамгаалах боломжгүй, хүрээлэн байгаа орчинд ихээхэн хэмжээний хор хохирол
учруулж болох тул Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6.1.5, Гал түймрийн улсын хяналтын
дүрмийн 3.1.5-д заасныг үндэслэн

ТОГТООХ НЬ:

1. – ны үйл ажиллагааг 20 ... оны ... дугаар сарын ... - ны өдрийн цагаас эхлэн түр зогсоосугай.
2. – ны ажиллагааг зогсоосон тухай нд албан ёсоор мэдэгдсүгэй.
3. Энэхүү тогтоол нь заагдсан зөрчлийг бүрэн арилгасны дараа гал түймрийн улсын хяналтын (ахлах) байцаагчаас ажиллагааг явуулах дүгнэлт гаргах хүртэл хүчин төгөлдөр байна.
4. Тогтоолыг эс зөвшөөрвөл 10 хоногийн дотор шүүх болон дээд шатны байгууллагад гомдлоо гаргах эрхтэй.

.....аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн гал түймрийн
улсын хяналтын (ахлах) байцаагч албан тушаалтай, цолтой
.....-ын / /

Гарын үсэг

Тогтоолыг хүлээн авсан: / /



**АРХАНГАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН
ЗААВАЛ БИЕЛҮҮЛЭХ АЛБАН ШААРДЛАГА**


_____ оны ____ сарын _____

дугаар _____

_____ хот

Г

Г





АРХАНГАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН
ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН МЭДЭГДЭЛ


_____ оны ____ сарын _____

дугаар _____

_____ хот

Г

Г





**АРХАНГАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫНХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН
ГАЛ ТҮЙМЭР ГАРСАН ТУХАЙ АКТ**


_____ оны ____ сарын _____

дугаар _____

_____ хот

Г

Г





АРХАНГАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН
ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ


_____ оны ____ сарын _____

дугаар _____

_____ хот

Г

Г





**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ
БАЙЦААГЧИЙН ТАНИЛЦУУЛГА**

_____оны _____сарын _____

дугаар _____

_____хот

Г

Г

